

 lendmn

# 2021 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

“ЛэндМН ББСБ” ХК



7707-0101

[www.lendmn](http://www.lendmn)



# Агуулга

<b>01</b>	Зээлийн үйл ажиллагаа	05
<b>02</b>	Бизнесийн үйл ажиллагаа	08
<b>03</b>	Харилцагчийн үйл ажиллагаа	15
<b>04</b>	Санхүүгийн үйл ажиллагаа	17
<b>05</b>	Эрсдэлийн удирдлага	20
<b>06</b>	Компанийн засаглал	22



## Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

# Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2 дахь жилдээ цахим хэлбэрээр амжилттай зохион байгууллаа.



О.БОЛДБААТАР (Гүйцэтгэх захирал)

Сайн байцгаана уу, эрхэм хүндэт харилцагчид, хамтрагч байгууллагууд болон хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид ээ!

Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилж байна.

Юуны өмнө та бүгдэд Дэлхий даяар хурдацтай тархаж буй COVID-19 халдвараас сэргийлэх зорилгоор “ЛэндМН ББСБ” ХК техник технологийн шийдлийг ашиглан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2021 оны 03-р сарын 20-ны өдөр “ЦАХИМ ХЭЛБЭР”-ээр 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулсныг дуулгахад таатай байна. Энэ нь Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт хувьцаат компаниудаас 2021 оны салхийг хагалсан хамгийн анхны хувьцаа эзэмшигчдийн цахим хурал гэдгээрээ онцлогтой байлаа.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны цэвэр ашгийн 20% буюу нийт 447,843,214.92 төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг болгон хуваарилах бөгөөд ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2021 оны 2 сарын 25-ны өдрөөр тасалбар

болгон гаргаж, 2021 оны 4 сарын 30-ны өдрийн дотор “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохоор зорин ажиллаж байна.

Компанийн хуримтлагдсан ашгийн түвшин жил бүр өсч бид санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр хувьцаа эзэмшигчдийнхээ үнэ цэнийг тасралтгүй өсгөсөөр ирсэн хэдий ч хувьцааны одоогийн ханш нь үнэ цэнийн хувьд хэт доогуур үнэлгээтэй буюу 2018 оны үнэ, цэвэр ашгийн харьцаатай харьцуулсан үнэлгээнээсээ 10 дахин бага, 2019 оныхоос даруй 2 дахин бага байна. Иймд, бид хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны үнэ цэнийг хамгаалах, хөрвөх чадвар муудсан үед нөөц хөрөнгө гарган хөрөнгийн эргэх чадварыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах нь зүйтэй хэмээн дүгнэн тодорхой хэмжээний хувьцаа эргүүлэн худалдан авах шийдвэр гарган ажиллаж байна. Үүний үр дүнд компанийн нэгж хувьцааны ханш 28.88 төгрөг байснаас 44.8 төгрөгт хүрч, 55.1%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Цар тахал дэлхий нийтэд төдийгүй Монгол улсын хэмжээнд тархаж эдийн засгийн хямрал үүссэн энэхүү хүнд цаг үед харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зээлийг үргэлжлүүлэн хэвийн олгож байгаа бөгөөд хүндрэл үүссэн харилцагчдад зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах боломжийг олгосоор байгаа төдийгүй шинэ харилцагчдад цахим зээлийн гэрээгээ нэг удаа өөрт ойрхон байршлаас сонгон, байгуулах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

“ЛэндМН ББСБ” ХК нь нийт харилцагч, хувьцаа эзэмшигч та бүхэндээ 2021 оны I улирлын санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна.

**Хүндэтгэсэн**

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал  
О.Болдбаатар



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Хиймэл оюун ухаанд суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ санхүүгийн салбарт шинэ жишиг тогтоогч таны АНД байна.



## АЛСЫН ХАРАА

Дэлхийн энтэй бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ Монголын санхүүгийн зах зээлд манлайлна.



**01**  
Инноваци



**06**  
Хүн төвт



**02**  
Хурд



**ҮНЭТ  
ЗҮЙЛС**



**05**  
Ухаалаг  
ажиллах



**03**  
Хариуцлага



**04**  
Тасралтгүй  
суралцагч



01

# Зээлийн үйл ажиллагаа


## Зээлийн үйл ажиллагаа

2021 оны I улиралд нийт хэрэглэгчдэдээ 37.6 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 182.5 мянган зээлийг LendMN аппликэйшнээр дамжуулан олгосон байна. Ингэснээр “ЛэндМН ББСБ” ХК-ийн харилцагчдадаа олгосон нийт зээлийн хэмжээ 830 тэрбум төгрөгт хүрч, нийт олгосон зээлийн тоо 3.9 сая болсон байна.


Түүнчлэн 2021 оны I улирлын зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2020 оны IV улиралтай харьцуулахад гэрээт харилцагчдын тоо 1%, олгосон зээлийн дүн 8%, цэвэр зээлийн багц 11%-иар тус тус өссөн амжилттайгаар бид 2021 оны I улирлаа үдлээ.

### 2021 оны I улирлын үзүүлэлтүүдийг өмнөх оны III, IV улиралтай харьцуулсан байдал


**Гэрээт харилцагчийн тоо**  
(Өссөн дүнгээр, мянган харилцагч)




**Шинээр олгосон болон сунгасан зээлийн тоо**  
(Мянган зээл)



**Шинээр олгосон болон сунгасан зээлийн дүн**  
(Тэрбум төгрөг)



**Цэвэр зээлийн багц**  
(Тэрбум төгрөг)





## Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд

2021 оны I улиралд COVID-19 цар тахлаас үүдэн авч хэрэгжүүлсэн байсан хөл хориог бууруулснаар зээлийн багцын чанарын үзүүлэлт сайжирсан буюу чанаргүй зээлийн багцад эзлэх хувь 7.3% болж буурсан байна. Түүнчлэн энэ улиралд зээлийн эрсдэлийн сангийн зардал 300 саяар буурч, 3.0 тэрбум төгрөгт хүрсэн ба зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ 135.7%-д хүрч, сайжирсан үзүүлэлттэй байна.

Зээлийн багцын чанарын үзүүлэлт (Тэрбум.төг)	2020.III	2020.IV	2021.I
<b>Нийт зээлийн багц</b>	<b>32.3</b>	<b>28.1</b>	<b>30.6</b>
Зээлийн эрсдэлийн сан	(2.1)	(3.3)	(3.0)
<b>Цэвэр зээлийн багц</b>	<b>30.2</b>	<b>24.8</b>	<b>27.6</b>
Хэвийн зээл	28.9	25.0	27.8
Хугацаа хэтэрсэн зээл	1.2	0.5	0.6
Чанаргүй зээл	2.2	2.6	2.2
Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	6.9%	9.1%	7.3%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	96%	130.4%	135.7%

02

# Бизнесийн үйл ажиллагаа



## “ЛэндМН ББСБ” ХК ногдол ашиг хуваарилахаар боллоо



“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх) нь Covid-19 цар тахлын улмаас дэлхийн болон Монгол Улсын санхүү, эдийн засагт хүндрэл учраад буй энэ цаг үед Компанийн менежментийн баг хамт олны хүчээр хувьцаа эзэмшигчид болон Компанийн ирээдүйд учирч болох эрсдэлийг оновчтой удирдаж, зохих хариу арга хэмжээг тухай бүр шуурхай хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагыг шат дараатай, үр дүнтэй нэгдсэн тогтолцоогоор ханган ажиллаж байна.

Ийнхүү эрсдэлийг оновчтой удирдсанаар Компани нь санхүү, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлийг өнгөрөгч 2020 онд амжилттай даван туулж, 2020 оны ашиг зорилтот түвшинд хүрсэн тул Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2021 оны 2 сарын 5-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрээр хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахаар болсон байна.

Компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу компанийн

2020 оны цэвэр ашгийн 20% буюу нийт 447,843,214.92 төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон хуваарилах бөгөөд ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2021 оны 2 сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, 2021 оны 4 сарын 30-ны өдрийн дотор “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохоор шийдвэрлэв.

Компанийн зүгээс цаашид хувьцааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр зорьж буй бөгөөд санхүү, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг 2021 онд ч амжилттай даван туулж, зах зээл дээрх шинэ жишиг тогтоогч, тэргүүлэгч байр сууриа улам батжуулахад бүхий л хүчин чармайлтаа гарган ажиллах болно.

# “ЛэндМН ББСБ” ХК хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг зарлалаа.



## “ЛЭНДМН ББСБ” ХК ХУВЬЦАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ ХӨТӨЛБӨРИЙГ ЗАРЛАЛАА

“ЛэндМН ББСБ” ХК санхүүгийн зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ танигдан, тэргүүлэхээс гадна олон нийтэд финтек компанийн анхны хувьцаа, анхны нээлттэй бондуудыг санал болгож Монгол Улсын хөрөнгийн зах зээл, түүний хөгжилд өөрийн бодитой хувь нэмрийг оруулсаар ирсэн билээ.

Харин энэ удаад бид өөрсдийн хувьцааны (MSE: LEND) хөрвөх чадварыг нэмэгдүүлэх үүднээс олон улсад нийтлэг хэрэгжүүлдэг хувьцаа эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг боловсруулж “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын 20/37 тоот тогтоолын дагуу “ЛэндМН ББСБ” ХК нь 2020 оны 12 сарын 24-ний өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржээс өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авахаар шийдвэрлэсэн билээ.

Компанийн хуримтлагдсан ашгийн түвшин жил бүр өсч бид санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр хувьцаа эзэмшигчдийнхээ үнэ цэнийг тасралтгүй өсгөсөөр ирсэн хэдий ч хувьцааны одоогийн ханш нь үнэ цэнийн

хувьд хэт доогуур үнэлгээтэй буюу 2018 оны үнэ, цэвэр ашгийн харьцаатай харьцуулсан үнэлгээнээсээ 10 дахин бага, 2019 оныхоос даруй 2 дахин бага байна. Иймд, бид хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны үнэ цэнийг хамгаалах, хөрвөх чадвар муудсан үед нөөц хөрөнгө гарган хөрөнгийн эргэх

чадварыг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах нь зүйтэй хэмээн дүгнэн тодорхой хэмжээний хувьцааг эргүүлэн худалдан авах хөтөлбөр зарласан бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 3 сарын 31-ний өдрийн байдлаар нийт халаасалсан хувьцааны тоо 37,609,730 байна.


Компанийн зүгээс хөрөнгийн зах зээлийн арилжааны идэвхи буурч буй энэ үед хувьцааны худалдан авалтыг дэмжсэнээр хувьцааны хөрвөх чадвар нэмэгдэн, компанийн үнэлгээ хэт доогуур үнэлэгдэхээс сэргийлэхээс гадна хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн үнэ цэнийг хамгаалах чухал ач холбогдолтой шийдвэр хэмээн үзсэн юм.

Дэлхий даяар тархаж буй халдварт өвчин, хөл хориотой холбоотойгоор дотоодын худалдаа, үйлчилгээ хийгээд эдийн засгийн бусад салбаруудын эргэц удааширч байгаа энэ мөчид бидний авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн энэхүү арга хэмжээ хувьцаа эзэмшигчдэд маань багахан ч болов хувь нэмэртэй байх болов уу хэмээн итгэж байна.



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 12 сарын 23-ны өдрийн ээлжит хурлын 20/37 тоот тогтоолын дагуу “ЛэндМН ББСБ” ХК нь 2020 оны 12 сарын 24-ний өдрөөс эхлэн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авах хөтөлбөрийг зарласнаас хойш компанийн нэгж хувьцааны ханш 44.8 төгрөгт хүрч, 55.1%-иар өссөн үзүүлэлттэй байна.

### Хувьцааны ханш



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

### Хөтөлбөр зарласнаас хойш

**55.1%**


Ханшийн өсөлт

**56.8 сая ширхэг**

Нийт арилжаалагдсан ширхэг

**1.9 тэрбум төгрөг**

Нийт арилжаалагдсан үнийн дүн



# Харилцагчдадаа зээлийн эргэн төлөлтийн таатай нөхцлийг үргэлжлүүлэн санал болголоо.

“ЛэндМН ББСБ” ХК нь харилцагчдадаа зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах нөхцөлийг үргэлжлүүлэн олголоо.

Монгол улсын хэмжээнд Covid-19 цар тахал дэгдэж улс орон даяар бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбоотой Засгийн Газрын шийдвэрүүдийг өөрийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа төдийгүй хатуу хөл хорионы үед цахим зээлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа билээ.

Монгол Улсын Засгийн Газраас гаргасан 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн шийдвэр (“Зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүссэн зээлийг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл сунгах”)-ийг

үндэслэн тус хугацаанд зээлийн эргэн төлөлтөд хүндрэл үүссэн харилцагч нартаа зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах нөхцөлийг үргэлжлүүлэн олгосоор байна.

Хөл хорионы улмаас харилцагч зээлээ хугацаандаа эргэн төлөхөд хүндрэл учирсан бол тухайн зээлийн үндсэн төлбөрийн 10%-ийг (хамгийн багадаа) шимтгэлийн хамт төлж зээлээ хэдэн ч удаа сунгах боломжтой юм.

Нийгмийн хариуцлагын хүрээнд харилцагчдынхаа санхүүгийн байдалд учирч болох эрсдэлийг хамтдаа шийдвэрлэх зорилгоор тухайн цаг үеийн шийдвэрүүдэд тохируулан түргэн шуурхай ажилласаар байна.




ЗЭЭЛИЙН ЭРГЭН  
ТӨЛӨЛТИЙН  
**ХУГАЦААГАА  
СУНГАХ ИЛҮҮ  
ХЯЛБАР БОЛЛОО**



www.lend.mn



7707-0101





## “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал цахим хэлбэрээр амжилттай боллоо.

Дэлхий даяар эрчимтэй тархаж буй COVID-19 цар тахлын халдвараас сэргийлэх зорилготой Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой Комисс болон Санхүүгийн Зохицуулах хорооноос гаргасан шийдвэр, зөвлөмжийн дагуу “ЛэндМН ББСБ” ХК өнгөрөгч 3-р сарын 20-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа цахим хэлбэрээр зохион байгууллаа. Хоёр дахь удаагаа цахим хэлбэрээр хийгдэж буй энэхүү хурал нийт хувьцаа эзэмшигчдэдээ эрсдэл учруулахгүйгээр, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан зохион байгуулагдлаа.

Хурлыг компанийн фэйсбүүк пэйж хуудсаар шууд дамжуулан үзүүлсэн бөгөөд энэхүү хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 79.59% нь оролцож компанийн үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлыг хэлэлцэн баталлаа. Үүнд:

- Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлан;
- Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт;
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны тайлан;
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох;
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох;
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны төсөв батлах;

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал О.Болдбаатар компанийн өнгөрсөн оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулан 2020 онд 2.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласны үр дүнд хувьцаа эзэмшигчдэдээ 447.8 сая төгрөгийн ногдол ашгийг тараахаар шийдвэрлэсэн бөгөөд 2021 оны 4-р сарын 30-ны өдөрт багтан үнэт цаасны дансаар нь дамжуулан хуваарилахаар болсон тухай мэдэгдлээ.

Харин “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ц.Одмаа компани өнгөрсөн онд эрсдэлийн удирдлагын бодлогыг амжилттай хэрэгжүүлж, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан тухай, мөн ТУЗ-ийн ажлын тайлан болон хараат бус гишүүнд нэр дэвшигчийг зарлаж танилцууллаа.

Хувьцаа эзэмшигчид урьдчилан хүлээн авсан нэвтрэх нэр, кодоор тусгай вэб хуудсанд нэвтэрч, хурлын ирцээ бүртгүүлж, хэлэлцэх асуудлуудтай холбоотой асуулт болон саналаа өгсөн бөгөөд энэ нь хүний оролцооноос шалтгаалсан алдаа гарахгүй энэ цаг үед тохирсон оновчтой, аюулгүй шийдэл болохыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын дарга “ЭмДиЭс энд ХаанЛекс” ХХН-ийн партнер С.Батбуян онцоллоо.





## Монголын шилдэг дижитал банкаар “ЛэндМН ББСБ” ХК-ийг 2 дахь удаагаа дахин тодрууллаа.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 онд хийж хэрэгжүүлсэн олон төрлийн ажлуудыг нэгтгэн дүгнэж банк санхүүгийн салбарын хөгжлийн түвшинг тодорхойлогч “AsiaMoney” сэтгүүлээс 2020 оны Монголын шилдэг дижитал санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээр LendMN-ийг тодруулж, 2019 оны гаргасан амжилтаа дахин бататгаж 2 дахь удаагаа энэхүү нэр хүндтэй олон

улсын шагналыг дахин гардан авлаа. Бидний энэхүү амжилт нь эрхэм харилцагчид, хөрөнгө оруулагчид, хамтрагч байгууллагууд та бүхний бидэнд итгэл хүлээлгэсэн хамтын ажиллагааны үр дүн билээ. Хамтдаа асуудлаа шийддэг харилцагч та бүхэндээ баярлалаа.



03

# Харилцагчийн үйлчилгээ

## Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 30 ажилтантайгаар хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2021 оны I улирлын турш нийт 69,999 удаагийн зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад үйлчилгээний талаар харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай үйлчилгээг үзүүлж тэдгээрийн 98.3%-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна. Улсын онцгой комиссоос хөл хорио тогтоосонтой холбоотойгоор харилцагчийн үйлчилгээний төв нь #АлсаасАсуудлааШийд уриатайгаар, цахим хэлбэрээр харилцагчийн үйлчилгээг цаг алдалгүй, тасралтгүй хүргэж байна. Нийт харилцагчдаа эрсдэлээс сэргийлж цахим хэлбэрээр бүхий л үйлчилгээгээ үзүүлж, тулгамдсан асуудлаа алсаас буюу гэрээсээ шийдэх боломжийг бүрдүүлэн ажиллалаа.



# #Алсаас Асуудлаа Шийд

✉ 140101

☎ 7707-0101

📘 LendMN

### 11 сек

Хүлээлгийн  
түвшин

### 69'999

I улирлын  
нийт дуудлага

### 98.3%

Үйлчилгээ  
амжилттай  
хүргэсэн



### 6'038

Сошиал сувгаар  
үйлчилсэн  
/Фэйсбүүк болон и-мэйл/



04

# Санхүүгийн үйл ажиллагаа

## Санхүүгийн байдлын хураангуй тайлан /Аудитлагдаагүй/

2021 оны I улирлын байдлаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 39.6 тэрбум төгрөг байгаагаас цэвэр зээлийн багц 27.6 тэрбум төгрөг, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 7.1 тэрбум төгрөг байна. Түүнчлэн өр төлбөр 22.2 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 17.4 тэрбум төгрөг байгаагаас хуримтлагдсан ашиг 8.1 тэрбум төгрөг байна.

Хөрөнгө (Тэрбум төгрөг)	2020.IV	2021.I
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	9.5	7.1
Зээлийн багц (цэврээр)	24.8	27.6
Бусад хөрөнгө	4.1	3.7
Үндсэн хөрөнгө	1.1	1.0
Биет бус хөрөнгө	0.2	0.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>39.7</b>	<b>39.6</b>


Өр төлбөр болон эздийн өмч (Тэрбум төгрөг)	2020.IV	2021.I
<b>Өр төлбөр</b>	<b>22.2</b>	<b>22.2</b>
Эх үүсвэр	20.5	19.6
Бусад өглөг	1.7	2.6
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>17.5</b>	<b>17.4</b>
Хувьцаат капитал	9.8	9.3
Хуримтлагдсан ашиг	7.7	8.1
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>	<b>39.7</b>	<b>39.6</b>

## Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдаагүй/


2021 оны I улирлын байдлаар компанийн нийт орлогын хэмжээ 3.0 тэрбум төгрөгт хүрч, 0.8 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан (Тэрбум төгрөг)	2020.IV	2021.I
Нийт орлого	3.2	3.0
Хүүгийн зардал	(1.1)	(0.9)
<b>Санхүүгийн цэвэр орлого</b>	<b>2.1</b>	<b>2.1</b>
Банк болон бусад шимтгэл	(0.4)	(0.4)
<b>Шимтгэлийн дараах орлого</b>	<b>1.7</b>	<b>1.7</b>
Эрсдэлийн сангийн зардал	(1.6)	0.3
<b>Эрсдэлийн сангийн дараах орлого</b>	<b>0.1</b>	<b>2.0</b>
Боловсон хүчний зардал	(0.5)	(0.6)
Үйл ажиллагааны бусад зардал	(0.5)	(0.5)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>(0.9)</b>	<b>0.9</b>
Татварын зардал	0.1	(0.1)
<b>Цэвэр ашиг</b>	<b>(0.8)</b>	<b>0.8</b>

**Шимтгэлийн орлого**  
(Тэрбум төгрөг)



**Цэвэр ашиг**  
(Тэрбум төгрөг)





05

# Эрсдэлийн удирдлага

## Эрсдэлийн удирдлага

Монгол улс болоод дэлхий дахинд эдийн засгийн хямрал үргэлжилж, хатуу хөл хорио тогтоож, байгууллага төдийгүй иргэдэд санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал үүссэн эгзэгтэй цаг үеийг туулж байна.

COVID-19 цар тахалаас үүдэлтэйгээр олон хямралууд үүсч байгаа энэ цаг үед эрсдэлийн удирдлагын төлөвлөлт, түүнийг зохистой хэмжээнд оновчтой удирдаж хэрэгжүүлсэн компаниуд оршин тогтнож, үйл ажиллагаагаа явуулж байна.

“ЛэндМН ББСБ” ХК нь COVID-19 цар тахалтай холбоотойгоор шинээр хэрэгжиж буй Монгол Улсын хууль, Засгийн Газрын тогтоол, шийдвэрүүдийг төдийгүй зохицуулагч байгууллагаас гаргасан мэдэгдэл, журмыг үйл ажиллагаандаа чандлан мөрдөж ажиллаж байгаа төдийгүй харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон компанид ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хариу арга хэмжээг цаг тухай бүр шуурхай авч хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй нэгдсэн тогтолцоог бүрдүүлж ажилласаар байна.

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2021 оны I улиралд 1.6 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 3.0 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 135.7%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

Компанийн тасралтгүй үйл ажиллагаа хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг урьдчилан олж илрүүлэх, бууруулах, хариу арга хэмжээ авахад чиглэж, компанийн мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын бодлогыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын хороогоор хэлэлцэж 2021 оны 2 дугаар сарын 5 өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлын 21/02 тоот тогтоолоор баталлаа.

2021 оны I улиралд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

## Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2020.IV	2021.I
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	52.1%	46.3%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	52.1%	46.3%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	20%-иас доошгүй	46.0%	44.0%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	43.2%	31.7%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	0.5%	5.4%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	55.2%	59.6%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	38.7%	36.7%


**06**

# Компанийн засаглал



## Компанийн засаглалын бүтэц

“ЛэндМН ББСБ” ХК нь компанийн сайн засаглалын тэргүүн туршлагыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж хувьцаа эзэмшигчдэдээ урт хугацааны үнэ цэнийг бий болгох, нэмэгдүүлэх, компанид итгэх итгэлийг бэхжүүлэн ажиллахыг эрмэлздэг төдийгүй Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, ил тод байдлыг хангах, нээлттэй тайлагнал, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг дотоод журмаар нарийн нягт зохицуулах зэрэг зарчмуудыг баримталж сайн засаглалын хэм хэмжээ, стандартыг бүрдүүлж ажилладаг.



## Төлөөлөн удирдах зөвлөл

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл 2021 оны I улиралд 1 удаа ээлжит хуралдаж нийт 11 тогтоол гаргав. ТУЗ-өөс гаргасан тогтоолуудаас дурдвал:

- “Эрнст энд Янг Монголиа Аудит” ХХК-аас компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, тайланг хангалттай гэж дүгнэсэн ба тус тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхээр тогтов.
- Компани 2020 оны жилийн эцсийн байдлаар 2.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан ба цэвэр ашгийн 20 хувьтай тэнцэх 447,843,214.92 төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэв.
- Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлав.
- Компанийн 2021 оны эх үүсвэрийн төлөвлөгөөг батлав.
- Компанийн бүтцийг шинэчлэн баталлаа.
- Компанийн Дотоод аудитын дүрмийг шинэчлэн батлав.
- Компанийн Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын бодлогыг батлав.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр цахимаар хуралдуулахаар шийдвэрлэж, хурлаар хэлэлцүүлэх асуудал, хурал зохион байгуулах болон тооллогын комиссын бүрэлдэхүүн зэргийг батлав.

## Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

### ТҮЗ-ийн дэргэдэх засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо

ТҮЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо 2021 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, холбогдох дүгнэлт гаргав. Үүнд:

- “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТҮЗ-ийн гишүүдийг улируулах сонгох талаарх Гүйцэтгэх удирдлагын саналыг үндэслэн, ТҮЗ-ийн гишүүдийн хурлын ирц, оролцоо, үр дүн зэргийг харгалзан үзэж ТҮЗ-ийн ердийн 6, хараат бус 2 гишүүнийг улируулан сонгох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх;
- ТҮЗ-ийн хараат бус түр гишүүн Болд овогтой Өлзийбаярыг ТҮЗ-ийн хараат бус гишүүнээр сонгох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх;
- ТҮЗ-ийн 2021 оны төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх.

### ТҮЗ-ийн дэргэдэх эрсдэлийн удирдлагын хороо

ТҮЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо 2021 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлыг ТҮЗ-ийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэв.

- Компанийн эрсдэлийн тайлан;
- Компанийн Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын төсөл;
- 2021 оны эх үүсвэрийн төлөвлөгөөний төсөл;

### ТҮЗ-ийн дэргэдэх аудитын хороо

ТҮЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 2021 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн, холбогдох асуудлыг ТҮЗ-д танилцуулан шийдвэрлүүлээ.

- Дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан;
- Дотоод аудитын дүрмийн шинэчилсэн төсөл;
- 2020 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын тайлан, зөвлөмж;
- Дотоод аудиторын 2021 оны ажлын төлөвлөгөөг батлах эсэх асуудал.





**ВЕБСАЙТ:**

[www.lend.mn](http://www.lend.mn)

**УТАС:**

7707-0101

**ИМЭЙЛ:**

[board@lend.mn](mailto:board@lend.mn)